



**ГАДААД ШИЛЖҮҮЛГИЙН ГҮЙЛГЭЭ ХИЙХ
ГҮЙЛГЭЭНИЙ МЭДЭЭЛЛЭЭ БАТАЛГААЖУУЛАХ
МЭДЭЭЛЭЛ ШИНЭЧЛЭХ ТУХАЙ**

Банк нь гадаадшилжүүлгийн гүйлгээг түргэн шуурхай дамжуулах, үйлчилгээгээ олон улсын жишигт нийцүүлэн харилцагчид хүргэхийн тулд гадаадын банк санхүүгийн байгууллагуудтай хамтарч ажиллаж, гаднын улс орны банкуудаар гүйлгээг дамжуулдаг бөгөөд гаднын улс орны банкуудын хэрэгжүүлдэг хууль тогтоомж, мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх (МУТСТ) болон Харилцагчийг таньж мэдэх ажиллагааны хяналт нь чанга, тавьж буй шаардлага нь өндөр байдаг.

Иймээс бид зөвхөн банкны үйл ажиллагаа төдийгүй улс орны гадаад харилцаа, эдийн засаг, олон улсын худалдаа, хамтын ажиллагаа, хөрөнгө оруулалтад нүүрлэх эрсдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэх зорилгоор холбогдох арга хэмжээг авч, харилцагчид болон харилцагчийн гүйлгээнд тодорхой шаардлагуудыг тавьж ажиллаж байгааг харилцагч та ойлгон хүлээн авч, хамтран ажиллана гэдэгт итгэж байна.

1

Банк яагаад харилцагчийн гүйлгээнд хяналт тавьж, гүйлгээтэй холбоотой мэдээллийг шаарддаг вэ?

Гадаад шилжүүлгийг дамжуулагч банкуудын зүгээс төлбөрийн зориулалтыг тодорхой бичих, төлбөр шилжүүлэгч, хүлээн авагчийн мэдээллийг бүрэн дэлгэрэнгүй байхыг шаардаж байгаа ба мэдээллүүд буруу, дутуу байх тохиолдолд төлбөрийг саатуулах, буцаах цаашлаад тусгаарлах, хураах хүртэл арга хэмжээг авах зэргээр хяналтыг улам чангатгаж байгаа юм. Иймд та дараах зүйлсийг анхаарна уу.

- Банканд данс нээлгэх, үйлчилгээ авахдаа өөрийн нэр, оршин суугаа хаяг, холбоо барих суваг, эрхэлдэг бизнес үйл ажиллагаа, хувьцаа эзэмшигчдийн талаарх мэдээллийг үнэн зөвөөр, бүрэн мэдээлэх.
- Төлбөр шилжүүлэх, гүйлгээ хийхдээ тухайн төлбөрийн зориулалт, утгыг дэлгэрэнгүй, тодорхой бичих.
- Төлбөр хүлээн авагч, хамтрагч түншийнхээ талаар тодорхой мэдээлэлтэй байж, төлбөрийн зориулалтыг бизнес, үйл ажиллагааныхаа чиглэлтэй уялдуулж бичих.
- Гуравдагч этгээдийн өмнөөс төлбөр шилжүүлэг хийхгүй байх.
- Интернет болон цахим банкны үйлчилгээ ашиглаж шилжүүлж байгаа тохиолдолд төлбөрийн мэдээлэл, гүйлгээний утгыг дэлгэрэнгүй зөв бичих.
- Төлбөр, шилжүүлэгтэй холбоотой банкнаас нэмэлт мэдээлэл, тодруулга шаардсан тохиолдолд мэдээллийг тухай бүрд нь бүрэн зөв, шуурхай гаргаж ирүүлэх.

2

Луйврын гүйлгээ хийгдэхээс сэргийлэх, гүйлгээний мэдээллийг бөглөхөд анхаарах зүйлс.

Гадаадын түншүүдтэйгээ и-мэйлээр харилцаж төлбөр шилжүүлэх тохиолдлууд ихэссэнтэй холбоотойгоор шилжүүлэгч болон төлбөр хүлээн авагч талууд и-мэйл хаягаа хакердуулах, фишинг и-мэйл хүлээн авах, луйварт өртөх эрсдэлтэй байдаг тул Харилцагч та төлбөр шилжүүлэгчийн мэдээллээ дараах байдлаар баталгаажуулж байна уу. Үүнд:

- Хүлээн авагчаас и-мэйл болон чатаар ирсэн дансны мэдээллийг гадаад шилжүүлэгч хийхээсээ өмнө хүлээн авагчтай заавал утсаар холбогдон, баталгаажуулж байх,
- Хүлээн авагч талын төлбөр байнга хүлээн авдаг байсан дансны дугаар ойрын хугацаанд өөрчлөгдсөн эсэхийг нягтлах, хэрэв өөрчлөгдсөн бол утсаар ярьж баталгаажуулах.
- Сугалаа, өв залгамжлал болон карго хүлээн авахтай холбоотой урьдчилгаа төлбөр шаардсан нь ихэнхдээ луйвар байдаг.

Тухайлбал, Зүүн өмнөд Азийн улс орнууд болох Индонез, Тайланд, Вьетнам, Филиппин болон Турк улс руу шилжүүлж буй ачаа тээвэр, ачаа тээврийн даатгалын төлбөр, өв залгамжлал, сугалааны азтан болсон тул мөнгө хүлээн авах гэсэн агуулга бүхий гүйлгээнүүд нь луйврын гүйлгээ байх магадлал өндөр байдаг. Иймд, луйврын гүйлгээнд өртөх эрсдэлээс урьдчилан сэргийлж хүлээн авагчаа таньж мэдэхгүй, баталгаажуулж чадаагүй, албан ёсны гэрээ, нэхэмжлэх байхгүй, Facebook болон бусад сүлжээгээр холбогдсон хүн рүү гүйлгээ хийхгүй байхыг анхаарна уу.

3

Мэдээлэл шинэчлэлт яагаад чухал вэ?

Банк харилцагчид үйлчилгээ үзүүлэх явцдаа харилцагчийн шаардлагатай мэдээлэлд өөрчлөлт орсон тохиолдолд тухай бүр мэдээллийг шинэчилж, банкны бүтээгдэхүүн, үйлчилгээг хүргэх үүрэгтэй байдаг. Мөн танд тохирсон банкны үйлчилгээг тасралтгүй, түргэн шуурхай хүргэх, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлж, хамгаалахад мэдээлэл шинэчлэлтийн гол зорилго билээ. Иймд та дараах мэдээлэл өөрчлөгдсөн тохиолдолд өөрт ойрхон банкны салбарт хандаж мэдээллээ тогтмол шинэчлүүлэн банкны бүтээгдэхүүн, үйлчилгээг цаг алдалгүй богино хугацаанд авах боломжтой.

- Ажил эрхлэлт, албан тушаал, бизнесийн үйл ажиллагааны чиглэл
- Холбоо барих утас, и-мэйл хаяг, гэрийн хаяг, ажлын газрын хаяг
- Байгууллагын хувьд хувьцаа эзэмшигч, эцсийн өмчлөгчийн мэдээлэл

Мэдээлэл шинэчлэлт хийгээгүйгээс үүсэж болох эрсдэл:

Харилцагч та мэдээллээ шинэчлээгүй, мэдээлэл хуучирсны улмаас банк хуульд заасан үүргийн дагуу харилцагчийг таньж мэдэх ажиллагаа хийхэд хүндрэл учрах бөгөөд дотоодын болон гадаад гүйлгээ саатах, цуцлагдах, өөрт тохирсон бүтээгдэхүүн, үйлчилгээгээ авч чадахгүй байх боломжтой. Мөн мэдээлэл шинэчлэлт огт хийгээгүй, банканд шаардлагатай мэдээллээ гаргаж өгөхгүй, худал мэдээлэл өгсөн тохиолдолд Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хуульд заасны дагуу банк харилцагчид үйлчилгээ үзүүлэхээс татгалзах үүрэг хүлээсэн байдаг билээ.

Таныг данс нээх, төлбөр тооцоо гүйцэтгэхэд банкнаас тавьж буй шаардлагууд нь Та болон таны бизнесийн түншийн төлбөр тооцоог саатаж, зогсоогдож болзошгүй эрсдэлээс сэргийлж, хамгаалж буй алхам юм.



ТА БҮХЭН, ДЭЛГЭРЭНГҮЙ МЭДЭЭЛЭЛ,
ЗӨВЛӨГӨӨ АВАХЫГ ХҮСВЭЛ АЖЛЫН ӨДРҮҮДЭД
КОМПЛАЙНСЫН ХЭЛТСИЙН **328086** ТООТ УТАС, **24**
ЦАГИЙН МЭДЭЭЛЛИЙН ЛАВЛАХ **1900-1977** ТООТ
УТСААР ХОЛБОГДОНО УУ.